



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/294

Эрдэнэт

Мал сүрэгт үзлэг ангилалт, хянан
баталгаажуулалт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 а, 29.2, Малын удмын сан эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4.5.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 23, 2015 оны 104 дүгээр тогтоол, "Монгол мал" үндэсний хөтөлбөрийн 3 дугаар хэсгийн 3.2, Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын 2 дугаар хэсгийн 2.1.1; 2.1.4; 2.1.5 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит IV хуралдааны II, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 63, 2017 оны ээлжит V хуралдааны 5/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үржлийн хээлтэгч, хээлтүүлэгч малд үзлэг ангилалт хийж, хянан баталгаажуулалт хийх ажлын удирдамжийг I, шаардагдах зардлыг II хавсралтаар тус тус баталсугай.

3. Үзлэг ангилалт, хянан баталгаажуулалтанд малчид, мал бүхий иргэдийг бүрэн хамруулж удирдамжинд заасан хугацаанд чанартай зохион байгуулж, ажлын үр дүн, тайлан мэдээг холбогдох газруудад хүргүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар /н.Бат-Өлзий/, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

2. Мал сүрэгт үзлэг ангилалт, хянан баталгаажуулалт хийхэд шаардагдах 3700000 /Гурван сая долоон зуун мянган/ төгрөгийг /шилмэл үүлдэр, омог хэвшлийн өсвөр хээлтүүлэгч малыг чиглэлтэй өсгөн бойжуулах, хээлтүүлэгч малын чанарыг сайжруулах/ зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

4. Ажлын явц, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /н.Баяржаргал/-д даалгасугай.



ЗАСАГ ДАРГА

Д.БАТЛУТ

**МАЛД ҮЗЛЭГ, АНГИЛАЛТ ЯВУУЛАХАД
 ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

Д/д	Явах газрын чиглэлийн нэр	Нэг удаа явах км	Нийт явах тоо	Бүгд явах /км/	100 км-т зарцуулах шатахуун /л/	Нийт шатахууны хэмжээ /л/	1 литр шатахууны үнэ/төг/	Нийт үнэ /төг/
1	Баянцагаан, 4подьём	250	3	750	18	135	1580	213300
2	Зүйл, Тариа бригад	300	3	900	18	162	1580	255960
3	Ханхар	300	3	900	18	162	1580	255960
4	Залуугийн өвөр, Бухын даваа	300	3	900	18	162	1580	255960
5	Нарангаас-Шувуут	350	3	1050	18	189	1580	298620
6	Дулааны энгэр, Хөшөөт, Ихэрийн бууц	350	3	1050	18	189	1580	298620
7	136 точек, Согоот, Хутагын шанаа	350	3	1050	18	189	1580	298620
8	Цагаан хуст, Арцатын даваа	300	3	900	18	162	1580	255960
9	Шатахууны дүн	2500	3	7500	18	1350	1580	2133000
10	Томилолт	8 хүн	3 удаагийн явалтанд				12000 /1өдөрт/	1440000
11	Хяналтын зардалд	223	2	446	18	80.3	1580	127000
	Нийт зардлын дүн							3700000